



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 4/359

Булган сум

“Архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх,
хэрэглэхийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу Хүүхдийн баяр”-ыг аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй өдөр болгон тэмдэглэсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр (00:00-23:59) архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, хэрэглэхийг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

